



**ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬ БАТЛАГДСАНТАЙ
ХОЛБОГДУУЛЖ АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ**

1994 оны 7 дугаар сарын 7-ны өдөр

Дугаар 60

Улаанбаатар хот

Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Дор дурдсан арга хэмжээ авахыг Засгийн газарт даалгасугай:

1)1995 оны 1 дүгээр сарын 1 нээс өмнө тогтоогдсон цэргийн тэтгэврийг амьжиргааны өртгийн өөрчлөлт, цэргийн алба хаасны тэтгэвэрт шинээр гарах хүмүүсийн тэтгэврийн хэмжээтэй уялдуулах арга хэмжээг 1997 онд багтаан хэрэгжүүлэх; /Үндсэн хуулийн цэцийн 1996 оны 04 дүгээр дүгнэлт, УИХ-ын 1996 оны 69 дүгээр тогтоолоор хүчингүй болсонд тооцсон./

2)Цэргийн албан хаагчийн тэтгэвэр,тэтгэмжийн тухай хуульд Засгийн газраас батлан мөрдүүлэхээр тогтоосон эрх зүйн актуудыг 1994 онд багтаан баталж гаргах;

3)Хилийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 11, 12, 13, 14 дэх хэсэг, Монгол Улсын аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 8 дахь хэсгийг Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 3, 4, 5 дугаар бүлгийн заалтуудтай уялдуулан авч үзэж зохих өөрчлөлт оруулах асуудлыг Улсын Их Хурлын энэ оны намрын чуулганаар шийдвэрлүүлэхээр өргөн мэдүүлэх;

4)цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн харилцааг зохицуулах асуудлаар урьд гарсан хууль тогтоомж, Засгийн газар (Сайд нарын Зөвлөл), түүний байгууллагуудын шийдвэрийг цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд 1994 онд багтаан нийцүүлэх;

5)хүн амын өсөлтийг дэмжих, эх нялхсын эрх ашгийг хамгаалах нийгмийн бодлогын хүрээнд цэргийн албан хаагч эмэгтэйчүүдэд жирэмсний болон амаржсаны тэтгэмж олгох асуудлыг боловсруулж Улсын Их Хуралд оруулах.

2.Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан генерал, офицер, ахлагчийн 1995 оны 1 дүгээр сарын 1-нээс өмнө алба хаасан хугацааг мөн хуулийн 22 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу шимтгэл төлсөн хугацаанд оруулан тооцох бөгөөд харин мөн зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу шимтгэлийг нь шилжүүлэн төлөх хугацаанд хамааруулахгүй байхаар тогтоосугай.

ДАРГА Н.БАГАБАНДИ